



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар A/605

Зуунмод

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016 оны А/620 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах аймгийн Ахмадын хорооны байрлаж буй барилгын доорх 4110010488 нэгж талбарын дугаартай 327 м² газрыг Орон нутгийн өмчийн газар /РД:3870235/-т 1-р баг, Жаргалан хотхон, Бодоогийн гудамж 311 тоот хаягт оффис, конторын зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Орон нутгийн өмчийн газар /Д.Батжаргал/-т дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Газар эзэмших эрхтэй холбоотой үйл ажиллагааны баримтын хуулбараар хувийн хэргийг тогтмол баяжуулж, газар эзэмших эрхийг баталгаажуулж байх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

3.4. Газар эзэмшигчийн хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчид шаардлага тавих.

ЗАСАГ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ



010107